



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 02

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 15 цаг 10 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ж.Гантулга, Г.Лхагвахатан, Л.Бат-Октябрь, Д.Эрдэнэбаатар, Б.Баярсайхан, Г.Болд, С.Бат-Эрдэнэ, Ж.Болд, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Сонссон нь 1:

Ч.Болормаа: Соёлын төвийн сонгон шалгаруулалтын дүн мэдээг танилцуулав.

Сонссон нь 2:

Галшар сумын төрийн сангийн мэргэжилтнээр нөөцөөс нэр дэвшүүлж өгнө үү гэсэн албан бичгийн дагуу судалж үзэхэд Ц.Одгэрэл нь 2017 оны 6 сарын 19ний өдөр төрийн сангийн мэргэжилтний ТЗ-3 дээр шалгалт өгөөд 78 оноогоор тэнцэж нөөцөд бүртгэгдсэн.

Нөөцөөс нөхөх зар явсаны дагуу Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Мөрөн суман дахь хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байран дээр Б.Цогбаяр өөрийн биеээр ирж бүртгүүлсэн. ХНХЯ-нд шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн.

Ж.Ганбаатар: ажлын байранд тавигдах шаардлага хангаж байна уу?

Ч.Болормаа: мэргэжил болон ажилласан жил ажлын байранд заасан шаардлагыг хангаж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Ж.Ганбаатар: Б.Цогбаярыг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Мөрөн суман дахь хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байран дээр уламжлах

Хэлэлцсэн нь:

Баян-Адрага сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга, Байгаль орчны улсын байцаагчийн сул орон тоо зарлах

Шүүхийн Тамгын газар мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтний ажлын байранд шалгалт зарлах

Жаргалтхаан, Баян-Адрага, Дэлгэрхаан сумын Соёлын төвийн эрхлэгчийн сул ажлын байр зарлах

Сонссон нь 3:

Ж.Ганбаатар: сул орон тоо зарлуулах хүсэлтүүд нь ирсэн үү. Ойрхон ойрхон шалгалт зарлах болоод байна. Соёлын төвийн эрхлэгч нарынхыг дахин зарлах Бид журмаараа нөөцөөс нөхөхөөр хүсэлт ТАЗ-д хүргүүлэх, соёлын төвийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг явуулах хүсэлтийг хүргүүлэх.

Сонссон нь 4:

Ж.Ганбаатар: Бор-Өндөр Шүүхийн тамгын газрын асуудал, ямар асуудалтай яана гээд байгаа вээ?

Б.Баярсайхан: Бор-Өндөрийн Шүүхийн Тамгын газар байгууллага дээрээ дотоод хяналт шалгалтыг хийж хүмүүсийн анх томилогдсон тушаал хууль зүйн үндэслэлтэй байна уу гэдгийг шалгаад үүн дээр 5 ажилтны анх томилогдсон тушаал холбогдох хууль тогтоомжийн дагуу томилогдоогүй байна тушаал нь бүрэн гүйцэд биш байна гэдэг зүйл ирсэн байгаа.

Үүн дээр Хэрлэнтуяа, Дагидмаа, Хэрлэн, Отгонцэцэг, Энхмаа. Эдгээр хүмүүс нь Бор-Өндөрийн Тамгын газартаа 3-10 жил ажилласан бүгдээрээ төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн, зарим албан хаагчид бүр төрийн албан хаагчийн зэрэг дэвээ авсан асуудал байна. Тэгээд ерөнхийдөө ямар асуудал байна вээ гэхээр анх эдгээр улсуудыг түр тушаалаар томилоод түр хугацаанд томилогдсон хугацаандаа шалгалтаа өгсөн. Тухайн үед хэлтсийн дарга нь салбар зөвлөлийн тогтоол авахгүйгээр дараагийн тушаалуудаа гаргаад явсан. Бүтцийн өөрчлөлт, ажилд шилжүүлэх ч юмуу ажилд дэвшүүлэх гээд дараа дараагийн тушаалуудыг гаргаад явсан. Анх салбар зөвлөлөөс тогтоол авч тушаалуудыг томилох ёстой. Бүгд салбар зөвлөлийн тогтоол байхгүй 5 хүн байгаад байна. Тэгсэн мөртлөө салбар зөвлөл дээр ирээд тангарагаа өргөөд явсан. 17.1 барьж томилоогүй Одоо салбар зөвлөлөөс өргөн бариад өгөөчээ гэж хүсэлт гаргасан. Эдгээрт нэг л тогтоолын төсөл гаргаад нэг л тогтоолоор шийдэгдэнэ.

Шийдвэрлэсэн нь: гишүүн Б.Баярсайхан тогтоолын төсөлийг хууль журмын дагуу бэлтгэж нарийн бичгийн даргаар гаргуулах холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.

Хурлын үйл ажиллагаа 17:30 минутад дуусав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
ХӨТӨЛСӨН:

Ч.БОЛОРМАА

